

"ХИШИГ-УУЛ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

“Хишиг-Уул” ХК (“Компани” гэх)-ийн 2023 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Монгол улс, Багануур дүүргийн Багануур дүүрэг, Нацагдоржийн гудамж хаягт байрлах Компанийн байранд 15:00 минутад эхлэв.

Хурал даргалагч Ядам овогтой Нэргүй: Компанийн ТУЗ-ийн 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн хурлаар хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын даргаар Нийслэлийн өмчийн газрын төлөөлөгчийг томилж, хурлын тов, хурлаар хэлэлцэх асуудлын материалыг Нийслэлийн өмчийн харилцааны газарт хүргүүлсэн боловч хуралд ирээгүй байна.

Үүнтэй холбоотойгоор тооллогын комиссын даргаар Компанийн энэхүү хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудалтай шууд холбоогүй компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолгүй этгээд болох С.Батчимэгийг томилох саналтай байна. Хуралд оролцож буй гишүүдэд татгалзах зүйл байгаа юу? Дэмжиж байна уу?

Хувьцаа эзэмшигч Ц.Роза: Татгалзах зүйл байхгүй, дэмжиж байна.

Хурал даргалагч Я.Нэргүй: Хурлын тооллогын комиссын даргаар С.Батчимэгийг томилсныг мэдэгдэж байна. С.Батчимэг хурлын ирцийг танилцуулна уу.

Хурлын ирц: Хувьцаа эзэмшигчдийн энэ удаагийн ээлжит хуралд 2023 оны 04 дүгээр сарын 10-ны тасалбар болгосон өдрийн байдлаар Компанийн нийт гаргасан 868,252 ширхэг энгийн хувьцаанаас 263,028 ширхэг буюу 30,29% хувийг эзэмшиж байгаа Я.Нэргүй хувьцаа эзэмшигч, 142,373 ширхэг буюу 16,39% хувийг эзэмшиж байгаа Ц.Роза нар хуралд биеэр оролцож, 37,130 ширхэг буюу 4.27% хувийг эзэмшдэг хувьцаа эзэмшигч Г.Байгалмааг итгэмжлэлийн үндсэн дээр хувьцаа эзэмшигч Я.Нэргүй төлөөлж оролцож байгаа нь энэ удаагийн хувьцаа эзэмшигчдийн хуралд Компанийн нийт саналын эрх бүхий энгийн хувьцааны 50.95% хувийг эзэмшдэг хувьцаа эзэмшигч оролцож байгаа болохыг хуралд оролцогчдод мэдэгдэж байна. Компанийн 34% хувийг эзэмшдэг нэг хувьцаа эзэмшигч буюу Нийслэлийн өмчийн харилцааны газраас энэ удаагийн хуралд оролцоогүй болохыг дурдаж байна.

Иймд Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Компанийн нийт саналын эрх бүхий энгийн хувьцааны 50.95%-ийн ирцтэйгээр оролцож байгаа тул Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүчин төгөлдөр ирцтэй эхэлж байна.

Хурал даргалагч Я.Нэргүй хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал болон хурлын дэгийг танилцуулав.

Нэг. Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;

Хоёр. Компанийн 2022 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;

Гурав. Компанийн 2023 оны Бизнес, үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн батлах;

Дөрөв. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг улируулан сонгох;

Тав. “Хэрлэн” худалдааны төвийн дээврийн капитал их засварын ажлын хөрөнгө оруулалтын асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх.

Нэгдүгээр асуудал. Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай

Хурал даргалагч Я.Нэргүй Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлангийн талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг танилцуулав.

Хурал даргалагч Я.Нэргүй:

Манай компани нь 2020 болон 2021 онд дэлхий нийтийг хамарсан цар тахлын хүнд үеийг даван туулахад их хүч хөдөлмөр гаргаж, өндөр зохион байгуулалттайгаар ажиллаж ирлээ. Хорио цээрийн үеийн Засгийн Газраас хэрэгжүүлсэн тэтгэвэр, нийгмийн даатгал, цахилгаан, дулааны зардлуудыг хөнгөлсөн хөнгөлөлтүүдэд Нийслэлийн өмчийн 34%-ийн оролцоотой гэдэг шалтгаанаар хамрагдаж чадаагүй нь компанийн үйл ажиллагаанд хүндээр тусч, хатуу хөл хорионы үед орлогогүй болж, ажилчдынхаа цалинг тавьж чадахгүйд хүрч, захирлууд цалингийн зээл авч хэд хэдэн удаа төлж барагдуулав. Гэвч бид хэмнэлтийн горим бодож хатуу сахилга батыг чанд сахин зохион байгуулалттай ажилласны үр дүнд борлуулалтын орлого 2020 онд 1,245 (нэг тэрбум хоёр зуун дөчин таван сая) байсан бол 2021 онд 1,407 (нэг тэрбум дөрвөн зуун долоон сая) болж өссөн сайн үр дүнд хүрлээ. Борлуулалтын орлого нэмэгдсэн боловч компанийн цэвэр ашиг буурсан нь төгрөгийн инфляц, хүнсний өргөн хэрэглээний барааны үнийн өсөлтөөс цэвэр болж цэвэр ашиг буурсан, 5,3 (тав аравны гурван) сая төгрөгийн ашигтай ажилласан. 2021 онд цар тахлын хөл хорионы үед гурван удаа манай үйлчилгээний төв хаагдах хэмжээнд хүрсэн бөгөөд борлуулалтын орлого буурсан нь бидэнд том цохилт болсон бөгөөд түрээслэгчид түрээсийн төлбөрөө төлөх боломжгүй байдалд хүрсэн цаг үеийг даван тууллаа. Манай компани 2022 онд цар тахлын хүнд үеийг туулсны дараа үр бүтээлтэй ажиллаж дээр дурдсанчлан 2021 онд 1,407 (нэг тэрбум дөрвөн зуун долоон сая) төгрөг байсан борлуулалтын орлого 2022 онд 1,684,617 (нэг тэрбум зургаан зуун наян дөрвөн сая зургаан зуун арван долоон) төгрөг болж өссөн үр дүнд хүрч цэвэр ашиг 6,400,000 төгрөг болсон. Борлуулалтын орлого 277,4 сая төгрөгөөр өссөн боловч бизнес үйл ажиллагаанаас гарсан үр дүнгийн ашиг харьцангуй бага гарч байгаа нь хүнсний бараа бүтээгдэхүүний үнэ өссөн, худалдан авагчдын худалдан авах чадвар суларснаас үүдэлтэй байна. 2023 онд үйл ажиллагаагаа нягтруулж, ажиллагсдын ажлын хариуцлагыг дээшлүүлж ажиллах болно.

Санал хураалт явуулахад хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчид Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлангийн талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг батлах асуудалд зөвшөөрсөн санал өгөв.

Хоёрдугаар асуудал: Компанийн 2022 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай

Тус Компани нь 2022 онд 16 гаруй ажиллагсадтайгаар Супермаркет дэлгүүр, ажлын байрны түрээс, зоогийн газар гэсэн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж ирсэн. Санхүүгийн

тайланг санхүүгийн байдал, үйл ажиллагааны орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлтийн, мөнгөн гүйлгээний тайлан гэсэн 4-н төрлөөр бэлтгэж гаргасан ба аккрузал суурьтай, балансын тоон үзүүлэлтүүд нь төгрөгөөр илэрхийлэгдсэн. Санхүүгийн Тайлангийн Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн.

Эргэлтийн хөрөнгө 240,146,084 мөнгө, үндсэн хөрөнгө 603,328,122 төгрөг, биет бус хөрөнгө 688,000 төгрөг, урт хугацаат хөрөнгө оруулалт 459,625,625 мөнгө, Нийт хөрөнгийн дүн 1,303,787,832 мөнгө болно.

Нийт үндсэн хөрөнгийн дүн 964,433,731.00 төгрөг, хуримтлагдсан элэгдэл 361,105,609 төгрөгийг хасаад үлдэх өртөг нь 603,328,122 төгрөг болно. Урт хугацаат хөрөнгө оруулалт 459,625,625 мөнгө байгаа нь үндсэн хөрөнгийн их засварын зардал бөгөөд барилга байгууламж дээр капиталжуулах ёстой.

Нийт өр төлбөрийн дүн 589,873,986 мөнгө, үүнээс урт хугацаат зээл 158,024,626 мөнгө.

Богино хугацаат өр төлбөр өмнөх онуудын дээвэр, засварын ажлуудыг хувийн хөрөнгөөр зассан зардал 431,849,360 мөнгө, эздийн өмч 713,913,846 мөнгө. Өр төлбөр ба эздийн өмчийн нийт дүн 1,303,787,832 мөнгө.

Компани нь 2022 онд 1,684,617,204 мөнгөний орлого олсноос Борлуулалтын өртөг 1,361,367,140 мөнгийг хасаад нийт ашиг 323,250,064 мөн үүнээс 316,027,898 мөнгөний ерөнхий ба удирдлагын зардлыг хасахад 7,222,166 мөнгөний ашигтай ажилласан болно.

Ингээд сүүлийн гурван жилийн байдлаар харьцуулсан хүснэгтийг танилцуулав.

Компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайлан хэлэлцсэн дүгнэлтийг ТУЗ-аас хэлэлцээд үйл ажиллагааны тайлангийн гүйцэтгэлийг хангалттай гэж дүгнэсэн байна.

Санал хураалт явуулахад хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчид Компанийн 2022 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах асуудалд зөвшөөрсөн санал өгөв.

Гуравдугаар асуудал: Компанийн 2023 оны Бизнес, үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн батлах.

Хувьцаа эзэмшигч Ц.Роза: Бизнес төлөвлөгөөний хувьд хамгийн гол ажил нь Хэрлэн худалдааны төвийн дээврийн их засварын ажлыг хийж гүйцэтгэх байгаа. Засварын ажлыг гүйцэтгэхдээ хөрөнгийг Я.Нэргүй захирал бусад хувьцаа эзэмшигчид зөвшөөрсний дагуу хийж гүйцэтгэнэ. 2023 оны 06 дугаар сард багтаж хийхгүй бол бороо ороод дээвэр маш хүнд нөхцөл байдалтай тулгарах тул дээврийн асуудлыг хурдан хугацаанд маш чанартай гүйцэтгэж хийх хэрэгтэй байна.

Дараагийн хамгийн гол ажил нь Компанийн борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх, тэгэхдээ супермаркетын борлуулалтын орлого болон захиалгаар ханган нийлүүлэх ажлыг хийхээр төлөвлөж байгаа.

Тэмдэглэлт ойн баяруудаар цаг үеийн эрэлт, шаардлагад нийцсэн бараа бүтээгдэхүүний өргөтгөсөн болон урамшуулалт худалдаа, бэлгийн багц бэлтгэх замаар захиалгат хүргэлтийн үйлчилгээ зохион байгуулахаар төлөвлөж байна.

Түүнчлэн 108 м³ гүн хөлдөөх камер шинээр байрлуулна. Энэ нь бол бид өөрсдийн махаа намар аваад хөлдөөгөөд үйл ажиллагаандаа зориулах юм.

Орон нутгийн телевиз, мэдээллийн байгууллагатай гэрээ байгуулан зар сурталчилгаа тогтмол явуулж, үйл ажиллагааг сурталчилна. Үүнийг бол бид өмнө нь хийдэг байсан, одоо үргэлжлүүлээд ажиллана.

Ашиглагдаагүй заал, талбайн ашиглалтыг сайжруулан заалны дүүргэлт, талбайн ашиглалтыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ шинээр худалдааны салбарыг нээх гэж байгаа. Ашиглагдаагүй талбай нэлээд их байгаа. Талбайн дүүргэлтийг бид жил жилээр нэмэгдүүлж байгаа. Тухайлбал, өнгөрсөн жил талбайн дүүргэлт маш муу байсан. Учир нь улсын хэмжээний цар тахлаас болж үндсэн түрээслэгчдээс хүртэл хүмүүс гарсан. Одоо Компани эргээд сэргэх байдалтай байгаа учраас ашиглагдаагүй талбайг ашиглахаар төлөвлөсөн байгаа.

Жавхлан хэсгийн ашиглагдаагүй зааланд их засвар хийж, заалыг ашиглалтад оруулах гэх мэтээр бүгдийг нь нарийн төлөвлөчихсөн байгааг хувьцаа эзэмшигчдэдээ урьдчилан танилцуулсан.

За мөн түүнчлэн жижиг засварын ажлууд байгаа. Барааны заалны жижиг орох хэсгийн шатыг янзлах, чулуун хана, шатны гишгүүр, бариул зэргийг шинэчлэн сайжруулна. Түүнчлэн рестораны сандал, ширээ, тавилга, тоног төхөөрөмжийг бүрэн шинэчилнэ.

Бөөний агуулахад цэвэрлэгээ хийгээд, дараа нь их засвар хийх төлөвлөгөөтэй байна. Энэ жил амжихгүй бол дараа жил хийнэ. Ямар ч байсан маш их хог цугларсан байгаа.

За тэгээд ресторанаа ашиглахын тулд сайн тогоочид, ер нь мэргэжлийн боловсон хүчид дутагдалтай байна. Тиймээс рестораны үйл ажиллагааг сайжруулахын тулд тандир зуухыг ашиглахаар бид хийсэн байгаа. Үүнийг арай ашиглаж амжаагүй байна. Ямар ч байсан 2023 ондоо ашиглаж, ирэх онуудад рестораны үйл ажиллагааг сайжруулах төлөвлөгөөтэй байна. Тэгээд энэхүү бизнесийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлын гүйцэтгэлийг оны эцэст дүгнээд явчих байхаа.

Санал хураалт явуулахад хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчид Компанийн 2023 оны Бизнес, үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн батлах асуудалд зөвшөөрсөн санал өгөв.

Дөрөвдүгээр асуудал. ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгох.

Хурлын даргалагч Я.Нэргүй: Улируулан томилох учраас гишүүдийн талаарх мэдээлэл, танилцуулгыг хувьцаа эзэмшигчид бүгд мэдэж байгаа. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг бүх брокер, диллерийн компаниудад мэдээллэсэн, олон нийтийн мэдээллийн сайтуудаар дамжуулсан, Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд холбогдолтой мэдээллийг өгсөн учраас хувьцаа эзэмшигч нар мэдэж байгаа байх.

Санал хураалт явуулахад хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчид Компанийн ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгох асуудалд санал хураах кумулятив аргын дагуу санал өгч, ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгохыг дэвжив.

Тавдугаар асуудал: “Хэрлэн” худалдааны төвийн дээврийн капитал их засварын ажлын зээлийн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх.

Хурлын даргалагч Я.Нэргүй: Хэрлэн худалдааны төвийн дээвэрт капитал их засвар хийх нэн шаардлагатай, тулгамдсан асуудал болж байгааг хувьцаа эзэмшигчид мэдэж байгаа, нөхцөл байдлыг бодитоор харуулах үүднээс Компанийн байранд энэ удаагийн хурлыг хуралдуулах болсон боловч төрийн хувьцаа эзэмшигч ирсэнгүй.

Дээврийн ус гоожиж байгаа, ус алдаж байгаа энэ асуудалд хэчнээн хэмжээний засвар үйлчилгээ, мөнгөн дүн шаардлагатай болох талаар Компанийн зүгээс мэргэшсэн төсөвчнөөр ажлын төсөв гаргаж, батлуулсан байгаа. Энэхүү зардлын төсвийн мэдээлэл нь хурлын зартай хамт хувьцаа эзэмшигч нарт урьдчилан хүргэгдэж, мэдээлэгдсэн байгаа учраас дэлгэрэнгүй танилцуулах шаардлагагүй байх.

Энэхүү төсөвт дээврийн засварын ажлын төсөвт өртөг нь 360,593,950 төгрөгийн өртгөөр засварлагдах тооцоолол гарсан. Үүнийг хувийн хөрөнгөөр засварлаж, зарцуулагдсан санхүүжилтийн мөнгөн дүнгээр давуу эрхийн хувьцаанд хөрвүүлэх нөхцөлтэй зээлийн гэрээг энэхүү хурлаар хэлэлцэхээр санал оруулсан байсан.

Дээврийн засварын санхүүжилтийн асуудлыг өмнөх хувьцаа эзэмшигчдийн хурлаар мөн оруулж байсан боловч өнөөдрийг хүртэл бүрэн шийдвэрлэгдээгүй, хамгийн тулгамдсан асуудлын нэг байгаа.

Энэхүү шаардлагатай төсвийг Компаниас шууд гаргах боломжгүй байгаа учраас хувьцаа эзэмшигчийн зүгээс Компанитай зээлийн гэрээ байгуулах саналыг урьдчилж гаргаж байгаа юм. Хувьцаанд хөрвөх нөхцөлтэй зээлийн гэрээний төсөл болон тус гэрээний гол нөхцөлүүдийг хувьцаа эзэмшигч нарт мэдэгдсэн, мэдээлэл хүргүүлсэн байгаа.

Тэгэхээр энэхүү хувьцаанд хөрвөх нөхцөлтэй зээлийн гэрээний нөхцөлийн хувьд 156,000,000 сая төгрөгийг, хүүгүй зээл хэлбэрээр 3 жилийн дотор төлөх нөхцөлтэй, хэрэв тус хугацаанд зээлийг төлөхгүй тохиолдолд хувьцаанд хөрвүүлэх нөхцөлийг санал болгож байгаа.

Тооллогын комиссын дарга С.Батчимэг: Энэхүү хэлцэл нь Компанийн тухай хуулийн 89.1 дэх хэсэгт заасны дагуу сонирхлын зөрчилтэй хэлцэлд хамаарч байх тул Компанийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байгаа, Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч Я.Нэргүй болон, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд хувьцаа эзэмшигч Ц.Роза нар саналын эрхгүйгээр оролцох ёстой.

Нийслэлийн өмчийн харилцааны газрын төлөөлөгч хуралд оролцох боломжгүй болсонтой холбоотойгоор энэ удаагийн ээлжит хуралд тус асуудал нь шийдвэрлэгдэх боломжгүй байгаа болохыг мэдэгдэж байна.

Хурал даргалагч Я.Нэргүй: За Нийслэлийн өмчийн харилцааны газрын төлөөлөгч хуралд оролцоогүй учраас энэ асуудлыг яаралтай дараагийн ээлжит бус хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэхээр тогтё.

Ингээд өнөөдрийн Компанийн ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурлыг өндөрлөө.

Хурал даргалагч Я.Нэргүй: Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар дараах асуудлыг шийдвэрлэлээ.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.
2. Компанийн 2022 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.
3. Компанийн 2023 оны Бизнес, үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсугай.
4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнд доор дурдсан нэр бүхий гишүүдийг улируулан сонгож, томилсугай. Үүнд:

Ердийн гишүүд:

1. Я.Нэргүй
2. Ц.Роза
3. Т.Отгонболд
4. С.Даваасүрэн
5. Н.Сүлд-Оргил
6. Б.Энххорлоо

Хараат бус гишүүд:

1. Д.Гонгор
2. Д.Сэржамц
3. Ж.Ганболд
4. “Хэрлэн” худалдааны төвийн дээврийн капитал их засварын ажлыг хийх зээлийн асуудлыг шийдвэрлэх сонирхлын зөрчилгүй хувьцаа эзэмшигчдийн ирц бүрдээгүй тул тус асуудлыг дараагийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар шийдвэрлэхээр хойшлуулсугай.
5. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийг хэрэгжүүлж хуульд заасан хугацаанд зохих журмын дагуу холбогдох эрх бүхий төрийн байгууллагуудад хүргүүлж, мэдэгдэхийг Өмгөөллийн “Сноу Хилл Консалтанси” ХХН-ийн хуульч Ш.Цэрэндолгор, А.Солонго, А.Тайван нарт даалгасугай.

Дээрх асуудлыг хэлэлцэж, санал хураалт явуулж дууссаны дараагаар Хурал даргалагч Я.Нэргүй хурал хаасныг мэдэгдэв. Хурал 2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 15:30 цагт хаав.

ХУРЛЫН ДАРГА:



Я.НЭРГҮЙ